



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 386

Улаанбаатар хот

Стратеги батлах тухай


Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтыг үндэслэн орон нутгийн хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, үр ашгийг сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

1. “Сумын эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний шинэчлэлийн стратеги”-ийг нэгдүгээр, Стратегийг хэрэгжүүлэх 2013-2015 оны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг олон улсын байгууллага, хандивлагчдын зээл тусламжаас зохицуулах, дотоодын эх үүсвэрээс гаргах замаар жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Я. Буянжаргал)-т даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А. Эрдэнэтуяа)-д үүрэг болгосугай.

САЙД



Н.УДВАЛ

84

Эрүүл мэндийн сайдын
2013 оны 10 сарын 16 өдрийн
386 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИНЭЧЛЭЛИЙН СТРАТЕГИ (2013-2018)

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Улсын Их Хурлаар 2011 онд батлагдсан Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад “Сум, тосгоны эрүүл мэндийн төв нь харьяа нутаг дэвсгэрийнхээ хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны аргаар үзүүлэх чиг үүрэгтэй” хэмээн тодорхойлсон. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 72 тоот тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө”-нд сумын эмнэлгийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг шинэчлэн “Сумын эрүүл мэндийн төв” болгохоор төлөвлөсөн бөгөөд “Тусламж, үйлчилгээний нэн шаардлагатай ба нэмэлт багц” (ТҮНШНБ)-ын дагуу сумын эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх анхан шатны болон ерөнхий мэргэжлийн тусламж, үйлчилгээг чанаржуулан бэхжүүлэхээр заасан болно.

Монгол Улсын Засгийн газраас “Сумын эмнэлгийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хөдөө орон нутгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн суурь тусламж, үйлчилгээний тэгш байдал, хүртээмж, чанарыг сайжруулах зорилгоор 2002-2008 онд хэрэгжүүлэн ажиллаж сумын эмнэлгийг бүтэц, үйл ажиллагааны стандартын дагуу ажиллах нөхцлийг бүрдүүлэн тоног төхөөрөмж, хүний нөөцийн хангамж зэрэг асуудлаар тодорхой үр дүнд хүрсэн боловч сумын эрүүл мэндийн төвөөр үзүүлж буй тусламж үйлчилгээний чанар тухайлбал, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, сумын эрүүл мэндийн төвийн санхүүжилт болон хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх асуудал тулгамдсан хэвээр байна.

2012 оны эрүүл мэндийн статистик үзүүлэлтээр сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлгийн орны тоо 2006 онтой харьцуулахад 636 –аар буюу 1.2 дахин, хэвтэн эмчлүүлэгчид болон амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо 1.1 дахин буурсан үзүүлэлттэй байна. Энэхүү үзүүлэлтээс харахад сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлгийн ор, хэвтэн эмчлүүлэгчдийн тоо буурч, эмнэлгийн орны фонд ашиглалт багассан байна. Азийн хөгжлийн банкны “Эрүүл мэндийн салбар хөгжил хөтөлбөр 3” төслөөс хийсэн судалгаагаар сумын эмнэлэгт шаардлагагүй хэвтэлт их байгаа нь тухайн өвчтөн эмчийн бичсэн жорын дагуу эм худалдан авах боломжгүй, бэлэн мөнгөгүйн улмаас эмнэлэгт хэвтэн эмчилгээ, үйлчилгээ авч байгаатай холбоотой гэсэн дүн гарсан байна.

2012 онд сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлэгт бүртгэгдсэн эхийн эндэгдэл 100000 амьд төрөлтөд 113,6 байгаа нь 2010 онтой харьцуулахад 2,9 дахин нэмэгдсэн байна.

2012 оны эрүүл мэндийн статистик мэдээллээр сумын эрүүл мэндийн төвүүд эмчээр хангагдсан хэдий ч өнөөгийн мөрдөж буй стандарттай харьцуулахад I зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвийн дөнгөж 9.7 хувь, II зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвийн 35.7 хувь байгаа нь шаардлага хангахгүй байна. Иймд сумын эрүүл мэндийн төвд ажиллах хүний нөөцийг стандартын дагуу хангах, тэднийг тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллуулахад чиглэгдсэн эдийн засгийн хөшүүрэг шаардлагатай байна.

Аливаа улс оронд эрүүл мэндийн анхан шатны тусламж нь олон нийтэд хүртээмжтэй байх, өвчнөөс урьдчилан сэргийлэх, орон нутгийн иргэдийг энэхүү үйл ажиллагаанд татан оролцуулах, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, өртөг зардал багатай технологи ашиглах зэрэг зарчим дээр тулгуурлан хөгждөг байна.

Иймд цаашид сумын эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээ, тусламж үйлчилгээ үзүүлэх хүчин чадлыг бодит хэрэгцээнд нь тулгуурлан оновчтой, зохион байгуулж, үр бүтээлтэй ажиллуулснаар орон нутагт эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулж, өртөг зардлыг бууруулах боломж бүрдэнэ хэмээн үзэж байна.

ХОЁР. ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хангалтгүй

- Орон нутгийн хүн амын зорилтот бүлэг тус бүрт шаардлагатай нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээний тэргүүлэх чиглэлүүдийг оновчтой тодорхойлоогүй,
- Нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээнд олон нийтийг дайчлан оролцуулах, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа дутмаг,
- Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, санхүүжилт дутмаг,
- Орон нутгийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд орчин үеийн нотолгоонд суурилсан анагаах ухааны мэдээ, мэдээлэл авах боломж багатай,
- Лабораторийн шинжилгээ болон бусад оношилгооны хэрэгслүүдийн чанарт тавих хяналт сул, оношилгооны чадамж хангалтгүй, хийгдэж буй оношилгооны төрөл хэт цөөн,
- Хуучирсан, хэрэглээнээс гарсан, ашиглагддаггүй, шаардлага хангахгүй эмнэлгийн тоног төхөөрөмжтэй,
- Эм, эмнэлгийн хэрэгслийг төвлөрсөн бус байдлаар хангаж байгаа өнөөгийн тогтолцоо нь орон нутагт чанарын шаардлага хангахгүй, хуурамч болон стандарт бус эм, эмнэлгийн хэрэгсэл хэрэглэж эрүүл мэнддээ учруулах эрсдлийг нэмэгдүүлж байгаа,
- Сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлэгт эмийг зохисгүй хэрэглэх явдал түгээмэл.

2. Удирдлага, төлөвлөлт, санхүүжилт хангалтгүй

- Аймаг, сумын түвшинд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй, орон нутаг дахь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний удирдлага, төлөвлөлт, хяналт үнэлгээ сул,
- Сумын эрүүл мэндийн төвд олгож буй санхүүжилт нь тусламж үйлчилгээний хэрэгцээ, бодит өртөгтэй уялдаагүй, алслагдсан байдал, ядуурлын индекс зэргийг харгалзаагүй,
- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилт хангалттай биш,

- 85
- Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж нь тэдгээрийн бодит хэрэгцээтэй уялдаагүй.

3. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, байршил оновчтой бус

- Эрүүл мэндийн анхан шатны тусламжийг орон нутагт олон төрлийн байгууллагууд (багийн эмчийн ортой салбар, тосгоны, сумын, сум дундын эмнэлэг) үзүүлж байгаа,
- Орон нутгийн хүн амын 60-аас доошгүй хувийг эзэлж байгаа ядуу, орлого багатай иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламжийг тэгш хүртээмжтэй, чанартай, цаг хугацаанд нь хүргэж чадахгүй байгаа,
- Аймгийн нэгдсэн эмнэлэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв болон сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны уялдаа хангалтгүй.

4. Хүний нөөцийн удирдлага болон эмнэлгийн мэргэжилтний ур чадвар сул

- Эрүүл мэндийн анхан шатны тусламжийг үзүүлэх эмнэлгийн мэргэжилтний тасралтгүй хөгжлийг хангах сургалтын чанар хүртээмж хангалтгүй,
- Сумын эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нар өрхийн анагаах ухаанаар мэргэшээгүй,
- Бүсийн оношилгоо эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлгийн эмч нар сумын эрүүл мэндийн төвийн эмнэлгийн мэргэжилтэнүүдэд зөвлөгөө зөвлөмж өгч, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллах хамтын ажиллагаа дутагдалтай.

5. Мэдээлэх, тайлагнах, хяналт-шинжилгээ хийх тогтолцоо сул

- Статистик мэдээ, тайлангийн үнэн зөв байдалд тавих чанарын хяналт оновчгүй,
- Өвчлөлийн тайлан мэдээ нь зарим талаар алдаатай, түүндээ зохих ёсоор дүн шинжилгээ хийдэггүй, тайлан мэдээг сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн хөрөнгө, санхүүгийн нөөцийг төлөвлөх, хуваарилахад ашигладаггүй.

ГУРАВ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сумын эрүүл мэндийн төвийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг илүү зохистой болгон өөрчлөх замаар орон нутгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулан анагаах ухаан, нийгэм, эдийн засгийн үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд энэхүү стратегийн ач холбогдол оршино.

Зорилго

Орон нутгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг өрхийн анагаах ухаанд үндэслэн цогц байдлаар хүргэж, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх.

Зорилт

1. Сумын эрүүл мэндийн төвөөр үзүүлж байгаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүрээг өргөтгөх, чанарыг сайжруулах

- 87
2. Сумын эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох, нэмэгдүүлэх
 3. Сумын эрүүл мэндийн төвийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох
 4. Сумын эрүүл мэндийн төвийн хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах,
 5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бүрдүүлж нотолгоонд тулгуурласан мэдээ, мэдээллийг төлөвлөлт хийхэд ашиглах чадавхийг бүрдүүлэх

Зорилт 1. Сумын эрүүл мэндийн төвөөр үзүүлж байгаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүрээг өргөтгөх, чанарыг сайжруулах

Хүрэх үр дүн:

- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ сайжирсан байна.
- Эмнэлзүйн үйл ажиллагаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар сайжирсан байна.
- Эмийн хангалтын найдвартай тогтолцоо бүрдсэн байна.

Сумын эрүүл мэндийн төвөөр үзүүлэх тусламж үйлчилгээг газар нутгийн байрлал, хүн амын өвчлөл, нас баралтын байдалд тулгуурлан нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээ гэсэн хэлбэрээр зохион байгуулна. Сумын эрүүл мэндийн төвөөр үзүүлэх тусламж үйлчилгээний тэргүүлэх чиглэл нь нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ байна. Үүний тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Сумын эрүүл мэндийн төвд нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр үзүүлэх тусламжийг сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэл, хүн амын өвчлөл, нас баралт зэрэгтэй уялдуулах, тусламж үйлчилгээг үзүүлэх арга зүйг боловсруулан гаргана.

Сумын эрүүл мэндийн төвөөр үзүүлэх тусламж үйлчилгээг өрхийн анагаах ухаанд суурилсан байдлаар шинэчлэн зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад орон нутгийн засаг захиргаа, төрийн болон төрийн бус байгууллага, сайн дурын идэвхтэн, хүрч очих ажилтан, үе тэнгийн сургагч нарын дэмжлэг идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор тэдэнд олгох урамшууллын механизмыг бий болгоно.

Иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний хүлээгдэл чирэгдлийг бууруулах зорилгоор сумын эрүүл мэндийн төвөөр хийгдэх шинжилгээний төрлийг нэмэгдүүлж, оношлуураар хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Нотолгоонд суурилсан анагаах ухааны эмнэлзүйн удирдамжийн дагуу тохиолдлын менежментийг хэрэгжүүлж хяналт тавина.

Архаг өвчний хяналт, тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах зорилгоор сумын эрүүл мэндийн төвөөр үзүүлэх тусламж үйлчилгээнд гэрийн болон өдрийн эмчилгээ, хөнгөвчлөх эмчилгээг нэвтрүүлнэ.

Орон нутгийн хүн амыг чанарын баталгаа бүхий зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй, хүртээмжтэй хангах зорилгоор дараах үйл ажилагааг хэрэгжүүлнэ.

Эмийн нөөц, хангалт, тайлагналт, эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх удирдлагын найдвартай тогтолцоо бий болгох зорилгоор суманд үйл ажиллагаа явуулж байгаа эмийн эргэлтийн санг сумын эрүүл мэндийн төвийн дэргэд байгуулна.

Эм, эмнэлгийн хэрэгслийг төвлөрсөн бус байдлаар хангаж байгаа өнөөгийн тогтолцоог өөрчлөн зохион байгуулж бүх сумын эрүүл мэндийн төвд эмийн хангалтыг төвлөрсөн байдлаар зохион байгуулна.

Хүрэх үр дүн:

- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ сайжирсан байна.
- Эмнэлзүйн үйл ажиллагаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар сайжирсан байна.
- Эмийн хангалтын найдвартай тогтолцоо бүрдсэн байна.

Зорилт 2. Сумын эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох, нэмэгдүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

Өнөөгийн байдлаар эрсдэл тооцсон нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн механизмыг илүү боловсронгуй болгож сумын эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний багцын бодит өртгийг тодорхойлох, түүнийг эрсдэл тооцсон нэг иргэний зардалтай уялдуулан тооцох (алслагдсан байдал, хүн амын өвчлөл, нас баралт, нас хүйс гэх мэт) үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Сумын эрүүл мэндийн төвөөр үзүүлж буй зарим тусламж үйлчилгээг эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх боломжийг судалж хэрэгжүүлнэ.

Үйлчлэх хүрээний хүн амын хэрэгцээ, сумын эрүүл мэндийн төвөөр үзүүлэх тусламж, үйлчилгээний багц, төвөөс алслагдсан байдал зэргээс хамаарч хэрэгцээт орны тоог шинэчлэн тогтоох.

Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн эрхлэгч, эмч нарыг санхүү менежментийн чиглэлийн сургалтанд хамруулж чадавхийг нэмэгдүүлнэ.

Хүрэх үр дүн:

- Сумын эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн механизм боловсронгуй болсон байна.
- Сумын эрүүл мэндийн төвийн санхүүжилт нэмэгдсэн байна.
- Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн эрхлэгч нарын санхүү, менежментийн чадавхи дээшилсэн байна.

Зорилт 3. Сумын эрүүл мэндийн төвийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

Эрүүл мэндийн анхан шатны тусламжийг үзүүлж буй сумын эрүүл мэндийн төвийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, үйл ажиллагааг өргөжүүлэх үйл ажиллагааны хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Сумын эрүүл мэндийн төвийн хүн амын тоо, насны бүтэц, тархан суурьшсан байдал, ядуурлын түвшин, нийгмийн хэрэгцээнд тулгуурлан төвүүдийн ангилал, бүтэц, үйл ажиллагааны стандарт, нөөцийн хуваарилалтыг үзүүлэх тусламж үйлчилгээний багцтай уялдуулан шинэчлэн боловсруулна.

Сумын эрүүл мэндийн төвөөр үзүүлэх тусламж үйлчилгээ нь өрхийн анагаах ухааныг суурь болгосон эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх байдлаар шинэчлэн зохион байгуулна.

Сумын эрүүл мэндийн төвийн эд хөрөнгө, тоног төхөөрөмжийн өнөөгийн байдлыг судлан сумын эрүүл мэндийн төвийн ангилал, зэрэглэлээр стандартын шаардлага хангах шинэчлэлийн төлөвлөгөө боловсруулж үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Хүрэх үр дүн:

- Сумын эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа боловсронгуй болж үйл ажиллагаа нь жигдэрсэн байна.
- Сумын эрүүл мэндийн төвөөр үзүүлэх тусламж, үйлчилгээ нь өрхийн анагаах ухаанд суурилсан байна.

Зорилт 4. Сумын эрүүл мэндийн төвийн хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх

Сумын эрүүл мэндийн төв нь хүн амд анхан шатны тусламж үйлчилгээг хүргэж байгаа гэдэг утгаараа тэнд ажиллаж байгаа эмч, сувилагч нар өрхийн анагаах ухаанаар мэргэших зайлшгүй шаардлагатай байгаа юм. Иймд одоогоор сумын эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа эмч, сувилагч нарыг өрхийн анагаах ухаанаар мэргэшүүлэх богино хугацааны түргэвчилсэн сургалтыг зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Сумын эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа эмч, сувилагч төдийгүй бусад эрүүл мэндийн ажилтнуудын сургалтын хэрэгцээг тогтоох, богино хугацааны сургалтыг зайн сургалт, ажлын байран дахь болон төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын хэлбэрээр зохион байгуулна.

Сумын эрүүл мэндийн төвд ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтний тогтвор суурьшилтай байдлыг хангах зорилгоор урамшууллын механизмыг нэвтрүүлнэ.

Хүрэх үр дүн:

- Сумын эрүүл мэндийн төвд ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтнүүдийн чадавхи нэмэгдсэн байна.
- Аймгийн төвөөс алслагдсан сумдад ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан урамшууллын механизм нэвтэрсэн байна.

Зорилт 5. Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

Анхан шатны тусламж үйлчилгээний бүртгэл мэдээлэлд нэгдсэн нэг стандарт бүхий программ хангамжийг нэвтрүүлнэ.

91

Сумын эрүүл мэндийн төвөөс дээд шатлалд илгээгдэн эмчлэгдэн гарсан үйлчлүүлэгчийн мэдээний санг солилцох журмаар өвчтөний үргэлжлэх шатны эмчилгээг сумын эрүүл мэндийн төвөөр хянах, үргэлжлүүлэх үйл ажиллагааг чанаржуулна.

Сумын эрүүл мэндийн төвүүдийг үйлчлэх хүрээний хүн амынхаа үндсэн бааз мэдээллийн чиглэлээр орон нутгийн хүн амын мэдээний сантай уялдуулж шилжилт хөдөлгөөний бүртгэл мэдээллийг сайжруулна.

Сумын эрүүл мэндийн төвд хөтлөгдөж буй анхан шатны бүртгэлийн маягтуудыг боловсронгуй болгох, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн үйл ажиллагаатай уялдуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хүн амын өвчлөл, нас баралтын мэдээ, тайланг сумын эрүүл мэндийн төвийн төлөвлөлтөнд ашиглах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чадавхийг бэхжүүлэх сургалтуудыг зохион байгуулна.

Сумын эрүүл мэндийн төвд зэрэглэлээс хамаарч алсын зайн анагаах ухааныг нэвтрүүлэх үйл ажиллагааг зарим сумдад эхлүүлнэ.

Дээрх чиглэлээр хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, техник тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хүрэх үр дүн:

- Хяналт - шинжилгээ үнэлгээний тогтолцоо боловсронгуй болсон байна.
- Мэдээ, мэдээллийн чанар сайжирна.
- Алсын зайн анагаах ухаан нэвтэрч үйлчилгээний чирэгдэл буурна.

ДӨРӨВ. СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сумын эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний шинэчлэлийн стратегийг 2013-2018 онд хэрэгжүүлнэ. Стратегийн хэрэгжилтийг үндэсний түвшинд удирдан зохион байгуулах үйл ажиллагааг Эрүүл мэндийн яам хариуцна. Орон нутгийн түвшинд аймгийн эрүүл мэндийн газар нь аймаг, сумын засаг даргатай хамтран стратегийн хэрэгжилтийг зохион байгуулна.

ТАВ. САНХҮҮГИЙН ХЭРЭГЦЭЭ


Сумын эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний шинэчлэлийн стратегийг хэрэгжүүлэх эхний үе шатанд нийт 27 тэрбум гаруй төгрөгийн санхүүжилт шаардлагатай урьдчилсан тооцоо гарч байна. Уг санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсөв, олон улсын зээл тусламж, төсөл, хөтөлбөрийн хүрээнд хамтран шийдвэрлэх замаар уг стратегийг хэрэгжилтийг хангана.

ЗУРГАА. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Стратегийн хэрэгжилтийн дунд хугацааны хяналт – шинжилгээг 2015 онд хэрэгжилтийн төгсгөлийн үнэлгээг 2018 онд тус тус хийнэ.

ДОЛОО. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Ерөнхий үзүүлэлт	2012	2018
Сумын эрүүл мэндийн төвөөр жилд үйлчлүүлсэн нэг иргэний дундаж үзлэгийн тоо	2.6	3.0
Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	43.2	45
Жирэмсний эрт үеийн хяналтын хувь	90.4	95 хувь
100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл	113.6	
1000 амьд төрөлтөнд ногдох нялхасын эндэгдэл	34.6	
Гэрийн төрөлтийн эзлэх хувь	-	
ШХБХ-ны эмчилгээ хийлгэж эдгэрсэн сүрьеэгийн шинэ (SS++)тохиолдлын эзлэх хувь	-	85%
Төрөлхийн тэмбүүгийн тохиолдлын тоо	-	-
Эрүүл мэндийн улсын зардалд эзлэх анхан шатны тусламж үйлчилгээний зардлын хувь	18,4	30
Сумын эрүүл мэндийн төвд ажиллаж буй эмч, сувилагч нараас өрхийн анагаах ухаанаар мэргэшсэн эмч, сувилагчийн эзлэх хувь	-	60 хувь
Анхан шатны бүртгэл мэдээллийн программ хангамжийг нэвтрүүлсэн сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн тоо / хувь	-	70 хувь
Алсын зайн анагаах ухааныг нэвтрүүлсэн сум дундын эмнэлгийн тоо/хувь	-	15/50 хувь




**СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИНЭЧЛЭЛИЙН СТРАТЕГИЙГ
2013-2015 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Үйл ажиллагаа	Үйл ажиллагаа	Үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтүүд	Эх сурвалж	Хариуцах байгууллага	Төсөв (сая төгрөгөөр)			
					2013	2014	2015	Бүгд
Зорилт 1. Сумын эрүүл мэндийн төвөөр үзүүлж байгаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүрээг өргөтгөх, чанарыг сайжруулах								
1.1.Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр	1.1.1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багцыг сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэл тус бүрээр боловсруулах	Тусламж үйлчилгээний багцын тоо	Багцыг баталсан тушаал	ЭМЯ	5.0			5.0
	1.1.2. Нийгмийн эрүүл мэндийн багцыг үзүүлэх арга аргачлалыг боловсруулан гаргах	Боловсруулсан аргачлалын тоо	Хэвлэгдсэн гарсан аргачлал	ЭМЯ, НЭМҮТ, Мэргэжлийн нийгэмлэг, ЭМСХХ		10.0	25.0	35.0
	1.1.3.Сумын эрүүл мэндийн төвд нийгмийн эрүүл мэндийн ажилтанг ажиллуулах	Нийгмийн эрүүл мэндийн ажилтнаар хангагдсан сумын эрүүл мэндийн төвийн эзлэх хувь	Сумын эрүүл мэндийн төвийн тайлан	ЭМЯ, Аймаг, орон нутгийн ЗДТГ				
	1.1.4.Сумын эрүүл мэндийн төвүүдэд сайн дурын ажилтан бэлтгэх сургалт зохион байгуулах	Бэлтгэгдсэн сайн дурын ажилтны тоо	Судалгааны тайлан, сумын эрүүл мэндийн төвийн тайлан	ЭМЯ, Аймгийн Эрүүл мэндийн газар, НЭМҮТ, ЭМСХХ		30.0	30.0	60.0

	1.1.5.Сайн дурын ажилтнуудад зориулсан сургалтын цогц гарын авлага боловсруулах түгээх	Боловсруулан гаргасан сургалтын гарын авлагын тоо, түгээгдсэн хувь	Хэвлэгдэн гарсан гарын авлага	ЭМЯ, ЭМХТ, НЭМУТ, ЭМСХХ	10.0	10.0
	1.1.6.Сумын эрүүл мэндийн төвд ажиллаж буй сайн дурын идэвхитэн, хүрч очих ажилтан нарт олгох урамшуулал бий болгох	Олгож буй урамшууллын төрөл	Сумын эрүүл мэндийн төвийн болон аймгийн эрүүл мэндийн газрын тайлан	ЭМЯ, Аймгийн Эрүүл мэндийн газар	3.0	3.0
	1.1.7.Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулах	Зохион байгуулсан сургалтын тоо, төрөл	Сумын эрүүл мэндийн төвийн тайлан	НЭМУТ, Орон нутгийн ЗДТГ, Сумын Эрүүл мэндийн төв	5.0	15.0
	1.2.1.Үйлчлэх хүрээний хүн амын өвчлөл, нас баралт, сумын эрүүл мэндийн төвөөр үзүүлэх тусламж, үйлчилгээний багцаас хамааран хэрэгцээт орны тоог шинэчлэн тогтоох судалгааг зохион байгуулах	Хийгдсэн судалгааны тоо	Судалгааны тайлан	ЭМЯ, ЭМХТ	5.0	5.0
1.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр	1.2.2.Сумын эрүүл мэндийн төв ашиглах орны тоог баталсан тушаалыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулах	Батлагдан гарсан сайдын тушаал	Эрүүл мэндийн сайдын тушаал	ЭМЯ	0.6	0.6
	1.2.3.Сумын эрүүл мэндийн төвд хийх түргэвчилсэн оношлуурын нэр төрлийг нэмэгдүүлэх, шаардлагатай түргэвчилсэн оношлуураар хангах	Тусламж үйлчилгээний багцад суусан түргэвчилсэн оношлуурын тоо Түргэвчилсэн оношлуураар бүрэн хангагдсан сумын эрүүл мэндийн төвийн эзлэх хувь	ЭМЯ	ЭМЯ, Аймгийн эрүүл мэндийн газар	1.0	9.0
						18.0

1.2.4.Түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийх сургалтанд сумын эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нарыг хамруулах	Сургалтанд хамрагдсан эмч, сувилагч нарын тоо	Сургалтын тайлан	ЭМЯ, ЭМХТ, Аймгийн эрүүл мэндийн газар	15.0	15.0	30.0
1.2.5.Сумын эрүүл мэндийн төвөөр хийх оношлогооны нэр төрлийг нэмэгдүүлэх, шаардагдах багаж тоног төхөөрөмжөөр хангах	Нэмэгдсэн оношилгооны нэр төрлийн тоо, шаардагдах багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан сумын эрүүл мэндийн төвийн эзлэх хувь	Эрүүл мэндийн сайдын тушаал эрүүл мэндийн яамны тайлан	ЭМЯ, Аймгийн ЭМГ, ЭМСХХ	12.0		12.0
1.2.6.Оношилгооны аргад эмч, сувилагч нарыг сургах сургалтыг зохион байгуулах	Зохион байгуулсан сургалтын тоо, төрөл	ЭМХТ, аймгийн эрүүл мэндийн газрын тайлан	ЭМХТ, Аймгийн Эрүүл мэндийн газар	15.0	15.0	30.0
1.2.7.Анхан шатны тусламж үйлчилгээний эмнэл зүйн удирдамж боловсруулах	Боловсрогдон гарсан эмнэл зүйн удирдамж	Хэвлэгдэн гарсан эмнэл зүйн удирдамж	ЭМЯ, ЭМХТ, ЭМСХХ, Мэргэжлийн зөвлөл, холбоод	15.0	15.0	45.0
1.2.8.Эмнэл зүйн удирдамжийг сургалт зохион байгуулах	Зохион байгуулагдсан сургалтын тоо	Сургалтын тайлан	ЭМЯ, ЭМХТ, ЭМСХХ, Мэргэжлийн зөвлөл, холбоод	30.0	30.0	90.0
1.2.9.Эмнэл зүйн удирдамжийн мөрдөлтөд хяналт -шинжилгээ хийх	Хийгдсэн хяналт шинжилгээ үнэлгээний тоо	Хяналт- шинжилгээ үнэлгээний тайлан	ЭМЯ, ЭМХТ, Аймгийн Эрүүл мэндийн газар	5.0	5.0	15.0
1.2.10.Сумын эрүүл мэндийн төвөөр үзүүлэх тусламж үйлчилгээний багцад өдрөөр болон гэрээр үзүүлэх тусламж болон хөнгөвчлөх тусламж үйлчилгээг оруулах	Багцад суусан тусламж үйлчилгээний төрөл	Эрүүл мэндийн сайдын тушаал	ЭМЯ	2.0	2.0	4.0


1.3. Эмийн эргэлтийн сангийн ажиллах журамд өөрчлөлт оруулах	1.3.1.Эмийн эргэлтийн сангийн ажиллах журамд өөрчлөлт оруулах	Өөрчлөлт орсон журмын тоо	Эрүүл мэндийн сайдын тушаал	ЭМЯ			3.0	3.0
	1.3.2.Эмийн эргэлтийн сангийн хөрөнгийг бүртгэлийг улсын мэдэлд шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	Эмийн эргэлтийн сан улсын мэдэлд шилжсэн сумын эрүүл мэндийн төвийн эзлэх хувь	Аймгийн эрүүл мэндийн газрын тайлан	ЭМЯ, Төрийн өмчийн хороо, Аймгийн Эрүүл мэндийн газар			3.0	3.0
	1.3.3.Эмийн эргэлтийн санд ажиллаж буй мэргэжилтнүүдийн цалингийн санг улсын төсөвт суулгаж шийдвэрлэх	Улсын төсөвт суулгаж шийдвэрлэлсэн байдал	Төсвийн тухай хууль	ЭМЯ, СЯ			2.0	2.0
	1.3.4.Эмнэл зүйн удирдамжинд үндэслэсэн эмийн зохистой хэрэглээний аудит хийдэг болох	Хийгдсэн аудитын тоо	Аудитын тайлан	эмхт, Аймгийн эрүүл мэндийн газар			15.0	15.0
	1.3.5.Аймгийн хэмжээнд эм ханган нийлүүлэх үйл ажиллагааг төвлөрсөн журмаар зохион байгуулах нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор эмийн агуулахыг аймгуудад байгуулах	Байгуулагдсан эмийн агуулахын тоо	Аймгийн эрүүл мэндийн газрын тайлан	ЭМЯ, Аймгийн эрүүл мэндийн газар, Гамшгаас хамгаалах ерөнхий газар			5000.0	5000.0
Зорилт 2. Сумын эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох, нэмэгдүүлэх								
	2.1.Сумын эрүүл мэндийн төвийн санхүүжилтийг хүн амын өвчлөл, нас баралт аймгийн төвөөс алслагдсан байдалтай нь уялдуулан ялгавартай тогтоох арга аргачлалыг боловсруулах	Боловсруулсан аргачлал	Батлагдсан сайдын тушаал	ЭМЯ, СЯ			5.0	2.0
								7.0




2. Сумын эрүүл мэндийн төвийн санхүүжилтийг хүн амын өвчлөл, нас баралт аймгийн төвөөс алслагдсан байдалтай нь уялдуулах чиглэлээр	2.2 Санхүүжилтийг ялгавартай олгох арга аргачлалыг орон нутагт хэрэгжүүлж эхлэх	Аргачлал хэрэгжсэн сумын эрүүл мэндийн төвийн эзлэх хувь	Хэрэгжилтийн тайлан	ЭМЯ, ЭМХТ	5.0	5.0	10.0
	2.3 Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багцын бодит өртгийг тооцох судалгааг хийх	Хийсэн судалгаа	Судалгааны тайлан	ЭМЯ, НМХТ, НЭМҮТ	35.0		35.0
	2.4 Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бодит өртгийг нэг иргэнээр тооцсон санхүүжилттэй уялдуулах тушаал журмыг боловсруулан гаргах	Боловсруулан гаргасан тушаал журмын тоо	Эрүүл мэндийн сайдын тушаал	ЭМЯ	3.0		3.0
	2.5 Сумын эрүүл мэндийн төвөөр үзүүлж буй зарим тусламж үйлчилгээг эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх боломжийг судлах, бүрдүүлэх	Хийгдсэн судалгаа	Судалгааны тайлан	ЭМЯ, СЯ, ХАХНХЯ	5.0		5.0
	2.6 Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн эрхлэгч, эмч нарыг санхүү менажментийн чиглэлийн сургалтанд хамруулах	Зохион байгуулсан сургалтын тоо, төрөл	Сургалтын тайлан	ЭМЯ, ЭМХТ	20.0	10.0	30.0
	Зорилт 3. Сумын эрүүл мэндийн төвийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох						
	3.1 Сумын эрүүл мэндийн төвийг зэрэглэлд хувааж үзүүлэх тусламж үйлчилгээний багцыг зэрэглэл тус бүрээр боловсруулж, эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулах	Боловсруулсан тусамж үйлчилгээний багц	Эрүүл мэндийн сайдын тушаал	ЭМЯ	5.0		5.0

3. Сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэлтэй уялдуулан бүтэц үйл ажиллагааны стандартыг шинэчлэн боловсруулах	3.2. Сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэлтэй уялдуулан бүтэц үйл ажиллагааны стандартыг шинэчлэн боловсруулах	Шинэчлэн боловсруулсан стандартын тоо	батлагдсан стандарт	ЭМЯ, Стандарт хэмжил зүйн үндэсний хороо	5.0	5.0
	3.3. Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн барилгын засвар үйлчилгээ, шинээр барих барилга	Шинээр барьсан барилгын тоо Засварласан барилгын тоо	Тайлан	ЭМЯ, Аймаг, сумын ЗДТГ, Аймгийн ЭМГ	5,000.0	15,000.0
	3.4. Сумын эрүүл мэндийн төвийн хөрөнгө, багаж тоног төхөөрөмжийн өнөөгийн байдлын үнэлгээг хийх	Хийгдсэн үнэлгээ	Үнэлгээний тайлан	ЭМЯ, ЭМХТ, Аймгийн Эрүүл мэндийн газар	12.0	12.0
	3.5. Үнэлгээний дүнд үндэслэн стандартын шаардлагын дагуу багаж тоног, төхөөрөмжийн хангалт хийх	Хангасан багаж тоног төхөөрөмж тоо, төрөл	Судалгааны тайлан	ЭМЯ, ЭМХТ, Аймгийн Эрүүл мэндийн газар	10.0	70.0
	Зорилт 4. Сумын эрүүл мэндийн төвийн хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх.					
3. Сумын эрүүл мэндийн төвийг өргөх аргаар шинэчлэн зохин байгуулах чиглэлээр	4.1.1. Сумын эрүүл мэндийн төвийн эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажлын тодорхойлолтын загварыг шинэчлэн боловсруулж баталгаажуулах	Эмч мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж баталгаажуулсан СЭМТ-ийн тоо	Ажлын байрны тодорхойлолт	Аймгийн Эрүүл мэндийн газар, СЭМТ	1.0	1.0
	4.2. Шинэчлэн боловсруулсан ажлын байрны тодорхойлолтоор уялдуулан сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг бүр хүний нөөцийн төлөвлөлт хийх	Хүний нөөцийн төлөвлөлт хийсэн СЭМТ-ийн тоо	Батлагдсан төлөвлөгөө	Аймгийн Эрүүл мэндийн газар, СЭМТ	2.0	2.0

4.1.Сумын эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтнуудын сургалтын хэрэгцээг тогтоох судалгааг зохион байгуулах	4.3.Сумын эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтнуудын сургалтын хэрэгцээг тогтоох судалгааг зохион байгуулах	Хийгдсэн судалгааны тоо	Судалгааны тайлан	ЭМЯ, ЭМХТ	5.0	5.0
	4.4.Судалгааны үр дүнд үндэслэн сургалтын төлөвлөгөөг боловсруулах	Боловсруулсан төлөвлөгөө	Батлагдсан төлөвлөгөө	ЭМЯ, ЭМХТ	3.0	3.0
	4.5.Сумын эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч, багийн эмч нарыг өрхийн анагаах ухааны чиглэлээр түргэвчилсэн сургалтанд хамруулах	Сургалтанд хамрагдсан эмч, сувилагч нарын тоо	Сургалтын тайлан	ЭМЯ, ЭМХТ, ЭМШУИС, Аймгийн Эрүүл мэндийн газар, сумын Эрүүл мэндийн төв	95.0	210.0
	4.6.Өрхийн анагаах ухааны түргэвчилсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулах	Боловсрогдон гарсан сургалтын хөтөлбөр	ЭМХТ-ийн тайлан	ЭМХТ	6.5	6.5
	4.7.Сумын эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг аймгийн нэгдсэн эмнэлэг болон Бүсийн оношилгоо эмчилгээний төвд эмнэл зүйн ур чадварын сургалтанд тогтмол хамруулах	Сургалтанд хамрагдсан эмч, сувилагч нарын тоо	Сургалтын тайлан	ЭМХТ, Аймгийн эрүүл мэндийн газар, Сумын эрүүл мэндийн төв, Аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ	120.0	120.0
	4.8.Зайн сургалт, ажлын байран дахь давтан сургалтыг зохион байгуулах.	Зохион байгуулсан сургалтын тоо, төрөл	Сургалтын тайлан	ЭМХТ, Аймгийн ЭМГ, сумын Эрүүл мэндийн төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ	8.0	8.0
						24.0



4.1.Сумын эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтнуудын сургалтын хэрэгцээг тогтоох судалгааг зохион байгуулах



5.1.Шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулах оновчтой арга зүйг боловсруулах, мэдээллийн чанарт тавих хяналтыг сайжруулах	Аймгийн эрүүл мэндийн газар, аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвөөс сумын эрүүл мэндийн төвд хийх мэргэжил арга зүйн зөвлөгөө, хяналтыг тогтмол хийх	Өгсөн мэргэжил арга зүйн удирдлагын тоо төрөл	Тайлан	ЭМХТ, Аймгийн Эрүүл мэндийн газар, сумын Эрүүл мэндийн төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЗТ	10.0	10.0	10.0	30.0
	Алслагдсан сумдад ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан урамшуулал олгох журам боловсруулж хэрэгжүүлэх	Боловсрогдон гарсан журам, урамшуулалд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо	Аймгийн эрүүл мэндийн газрын тайлан	ЭМЯ, Аймгийн Эрүүл мэндийн газар	3.0			3.0
Зорилт 5. Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох								
5.1.1.Анхан шатны тусламж үйлчилгээний бүртгэл мэдээлэлд нэгдсэн нэг стандарт бүхий программ хангамжийг боловсруулах	Боловсруулсан программ хангамж	Боловсруулсан программ хангамж	Боловсруулсан программ хангамж	ЭМЯ, ЭМХТ	80.0			80.0
	5.1.2.Программ хангамжийг сумын эрүүл мэндийн төвд суурилуулах	Программ хангамжийг ашиглаж буй сумын эрүүл мэндийн төвийн эзлэх хувь	Судалгааны тайлан	ЭМХТ, Аймгийн Эрүүл мэндийн газар		5.0		
	5.1.3.Программ хангамжийн сургалт зохион байгуулах	Зохион байгуулсан сургалтын тоо, төрөл	Сургалтын тайлан	ЭМЯ, ЭМХТ, Аймгийн Эрүүл мэндийн газар		100.0		100.0
	5.1.4.Сумын эрүүл мэндийн төв, болон сум дундын эмнэлэгт хөтлөгдөж буй анхан шатны бүртгэлийн болон тайлангийн маягыг шинэчлэн боловсруулах	Шинэчлэн боловсруулсан маягтын тоо төрөл	ЭМ-ийн сайдын тушаал	ЭМЯ, ЭМХТ		3.0		3.0

100

5.1.5. Сум дундын эмнэлэгт алсын зайн анагаах ухааныг нэвтрүүлэх үйл ажиллагааг эхлүүлэх	Үйл ажиллагааг эхлүүлсэн сум дундын эмнэлгийн тоо	Үйл ажиллагааны тайлан	ЭМЯ, ЭМХТ, Аймгийн Эрүүл мэндийн газар	350.0	150.0	150.0	650.0
5.1.6. Хяналт шинжилгээ үнэлгээний чиглэлээр сургалт зохион байгуулах	Зохион байгуулсан сургалтын тоо, төрөл	Сургалтын тайлан	ЭМХТ, Аймгийн Эрүүл мэндийн газар	3.0	10.0	10.0	23.0
5.1.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээлэл цуглуулж, мэдээллийн сан бий болгох.	Бий болсон мэдээллийн сангийн тоо	Сумын эрүүл мэндийн төвийн тайлан	ЭМХТ, Аймгийн Эрүүл мэндийн газар, сумын Эрүүл мэндийн төв		5.000	3.000	8.000
Бүгд				5.675.0	10,728.1	11,174.0	27,577.1